

Бизнес эрхлэгчдийн сэтгэгдэл



Б.Мөнхдэлгэр

“Би санхүүгийн менежмент сургалтад хамрагдаж, энгийн хирнээ урьд өмнө олж хараагүй зүйлсийг олж харсан. Бизнес эрхэлж байгаа хүн аливаа ажлыг мэргэжлийн түвшинд хийх, хувийн болон компанийн тооцоог ялгаж салгаж, хуримтлал, элэгдэл хорогдлын сан байгуулах гээд ирээдүйд хэрхэн бэлтгэх талаар олон хэрэгтэй зүйл сурч, хэрэгжүүлж эхлээд байна.”



Б.Чулуун

“Хамт олноо удирдахуй сургалтаар өөрийгөө хэн бэ гэдгээ танин мэдэж, ажилчдаа таних, ажилд авахдаа хэнийг ямар ажилд томилох вэ гэдгийг сайн ойлгож авлаа. Хувь хүний үнэлгээний арга барил их таалагдлаа. Сурсан зүйлээ амьдралдаа хэрэгжүүлэхийг хичээлж ажиллах болно.”


**“Боловсрол эзэмшихийн
зорилго нь мэдэхэд бус
хэрэгжүүлэхэд оршино.”**
Хэрбэрт Спэнсэр



С.Золзаяа

“Би их сургуулийн дөрвөн жилд үзсэн хирнээ ойлгож чадаагүй санхүүгийн үндсэн зарчмыг дөрвөн өдрийн дотор хялбархан, энгийн аргаар заалгаж мэдэж авлаа. Би BPN-ийн санхүүгийн менежмент сургалтад сууснаар

- өөрөө өөрөөсөө хулгай хийж байгаагаа,
- компани өөрийн гэр бүлийн хүн шиг халамжилж, байнга тордож, дүн шинжилгээ хийж сайжруулж мөн хөгжүүлж болохыг,
- зөв газарт, зөв цагт, зөв хөрөнгө оруулалт хийх ёстойг,
- хэсэгхэн хугацаанд их хэмжээний ашиг олох гэж улайрахаас илүү компанийн үнэ цэнийг нэмэгдүүлж, баялаг бүтээхийн төлөө ажиллах ёстойг ухаарлаа. Ханс багцдаа баярлалаа”.




Хаяг:
СБД, 8-р хороо
Оюутны 33
"ТАНАН" төв, 404 тоот

Утас:
77113309, 70113309

И-Мэйл:
info@bpn.mn



BPN
Business Professionals Network



Монголын Үйлдвэрлэлийн Хөгжлийн Төлөө



Оны дугаарт:

- Олон улсын үйл ажиллагаа хариуцсан захирлын үг
- Жижиг, дунд компаниудын нөлөө
- Бизнес академи
- Бизнес эрхлэгчдийн нийгэмлэг
- Энэ оны хөтөлбөрийн оролцогчид
- Бизнес эрхлэгчдийн сэтгэгдэл

2016





Ханс Вилхэлм Олон улсын үйл ажиллагаа хариуцсан захирал

Эрхэм хүндэт бизнес эрхлэгчидээ, хөтөлбөрийн оролцогчидоо
Улиран одож буй 2016 он дэлхий дахинаа улс төрийн болоод эдийн засгийн хувьд өөрчлөлтөөр дүүрэн он байлаа. Эдгээр өөрчлөлтүүд нь ямар үр дагавартай вэ гэдгийг өнөөдөр бид хараахан мэдэхгүй. Олон хүмүүс айдастай, үл итгэсэн байр суурьтай байгаа бол харин зарим нэг нь үүнийг боломж гэдэг өнцгөөс харж байна. Гэвч хамгийн гол нь хүн бүр эрүүл, аюулгүй амьдрах хэрэгцээгээ хангаж, амьдрах орчин нөхцлөө сайжруулах явдал чухал юм.

Хэдийгээр улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдсөн ч бизнес эрхлэгчид чухал хүмүүс хэвээр үлддэг. Нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй бизнес эрхлэгчдийн хувьд улс орондоо хамгийн үнэ цэнэтэй байдаг. Тэд зөвхөн өсөлтийг бус ажлын байр бий болгодог. Өсөлт бий болгох, утга төгөлдөр ажил хийхийн аль аль нь эрүүл ухамсартай байх үндсэн шалгуур юм. Үүнийг танин мэдсэнээр бүх бизнес эрхлэгчдэд компаниа өсгөж, цаашид хөгжүүлэх урам зориг, эрч хүч, итгэл үнэмшлийг төрүүлдэг. BPN-ийн хөтөлбөрт хамрагдсанаас хойш бизнесийн чиглэлээр сурсан зарчим, үнэт зүйлүүдээр өсөлтийг бий болгох явцдаа зөвөөр ашиглаж байгаа бизнес эрхлэгчийг харахад миний хувьд бахархалтай байдаг. Тиймээс BPN мэргэжлийн бизнес эрхлэгчдийг улам хөгжүүлэхийн тулд цаашид хувь нэмрээ оруулсаар байх болно.

Өнгөрсөн онд зарим бизнес эрхлэгчид хямралын шуурганд нэлээд өртөж байгаа нь ажиглагдлаа. Зарим нь бүр оршин тогтнож чадах уу үгүй юу гэдэг ирмэг дээр хүртэл ирээд байна. Хэрэглэгчид илүү шүүмжлэлтэй бас хэмнэлттэй худалдан авалт хийх болсон тул бараа бүтээгдэхүүн урьдын адил зарагдахаа больж, зарим бизнес эрхлэгчдийн борлуулалтын хэмжээ эрс буурч байна. Зарим бизнес эрхлэгчдийн хувьд бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжөө шинэчилж, сайжруулахад зайлшгүй шаардлагатай хөрөнгө мөнгөөр гачигдаж байна. Өөрчлөлтийг зайлшгүй хийх шаардлагатай! Зарим нь өөрчлөлт хийж байхад, зарим нь хийхгүй сууж байна. BPN-ийн сургалтад сууж, өөрчлөлт хийж чадсан зарим бизнес эрхлэгчдийн хувьд хүнд хэцүү үеийг хялбархан даван туулах боломж бүрдсэн. Учир нь тэдний хувьд бүтээгдэхүүн, ажилтнуудаа хөгжүүлж, тоног төхөрөөмжөө шинэчилж сайжруулан сайн цаг үед үйлдвэртээ зөв хөрөнгө оруулалт хийж, сайн ажиллаж байсан юм. Цаашилбал тэдний дунд хуримтлал бий болгож, хэцүү цаг үеийг даван туулахад сайтар бэлтгэгдсэн нэг нь ч бий. Хямрал тэднийг тойрч гарахгүй ч, тэднийг үгүй болгож чадахгүй нь дамжиггүй.

Бусад хүмүүст энэ цаг үе хүндээр тусч, зарим нэгэн үйлдвэрүүдийг аварч үлдэх боломжгүйд ч хүрч магадгүй тийм үе тулгараад байна. Учир нь тэд өөрчлөлтийг шаардлагатай цаг үед нь хийж чадаагүй юм. Харамсалтай нь зах зээлийн хууль хэнийг ч өршөөдөггүй ба хэрэглэгч бизнес эрхлэгчдэд энэрэнгүй ханддаггүй. Тэд хаана, хэн илүү зүйл санал болгож байна, түүнийг сонгодог.

Нэг сайн зүйл гэвэл хийсэн алдаанаасаа суралцахад хэзээ ч оройтдоггүй. Өөрчлөлт бол хүний амьдралд байх ёстой зүйл юм. Хамгийн гол нь бид өөрчлөлтөд хэрхэн зөв хариу үйлдэл үзүүлэх вэ гэдэг нь чухал байдаг. Үүнтэй холбоотой “Чи өнөөдрийг хүртэл ажилласан чигээрээ ажиллаад байвал одоог хүртэл хураасан ургацаасаа илүүг хурааж чадахгүй” гэсэн үг бий.

Тиймээс би таныг өөрийн оршин буй орчин тойрондоо өөрчлөлтийг эерэг хөгжил болгон ашиглаасай гэж хүсч байна. BPN байгууллагын хувьд ирээдүйд сургалтаас гадна зөвлөх үйлчилгээгээ илүү сайжруулж, бэхжүүлэхээр ажиллаж байна. Тэгснээр бид бүхэн бизнес эрхлэгчиддээ хүнд хэцүү цаг үед нь илүү дэм болж чадна.

Дэлхий дахинаа бий болоод байгаа улс төрийн болон эдийн засгийн өөрчлөлтүүдийг далимдуулан хятадууд хэрхэн сайн бизнес хийх вэ гэдэгт анхаарлаа хандуулж байна. Тэдний хийж буй хөрөнгө оруулалтууд үр жимсээ өгч, өнөөдөр тэд эдийн засгийн хувьд тэргүүлж чадаж байна. Тэд зөвхөн улс орондоо төдийгүй дэлхийн өнцөг булан бүрт бүх зүйлд гар бие оролцож байна. Хятадууд олон орны компаниудад хөрөнгө оруулалт хийж, улс орныг нь хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ хэмээн амалж байна. Тэд ямар зорилготой байна вэ? Тэд тухайн улс орнуудын технологи, зах зээлийг эзлэх гэсэн санаа зорилго агуулж байгаа нь дамжиггүй. Тэд тухайн улс орны үйлдвэрүүдэд хөрөнгө оруулалт хийх сайхан санал тавьж, ингэснээрээ байр сууриа бэхжүүлж, нөлөөлөхөөр санаархаж байна. Зарим нэгэн амжилттай яваа үйлдвэрүүдийг Хятадууд аль хэдийн эзлэн авсан байна. BPN-ийн хөтөлбөрийн оролцогчид дотор ч мөн ялгаагүй хөрөнгө оруулалтын санал авсан хүмүүс байна. Хятадууд хамгийн түрүүнд хамгийн амжилттай яваа компани, үйлдвэрүүдийг сонгож авдаг.

Тийм учраас BPN-ийн зүгээс хөрөнгө оруулалтын „санал“-уудыг хүлээн авахаас болгоомжилж, бизнес эрхлэгчдийг өөрийнхөөрөө байж, компанидаа бие даан хөрөнгө оруулалт хийж, хөгжлийг тогтвортой бөгөөд алхам алхмаар хийж урагшлаасай хэмээн хүсч, зоригжуулахыг хүсч байна.

Миний бие бүх бизнес эрхлэгчиддээ ирж буй онд амжилт, эр зоригийг ерөөж, бизнесийн удирдлагын чиглэлээр сурсан бүхий л мэдлэгээ хэрэгжүүлэх үйлсэд нь амжилт хүсч байна. Эрүүл оршин тогтнож, хөгжиж байгаа компани бол хөгжин буй эдийн засгийн амжилтын хамгийн тулгуур хүчин зүйл байдаг.

“Амжилт”-ыг ахар богино хугацаанд олохыг хүсч буй хэн бүхэн, уналтыг амархан шүүрдэж чаддаг. Сууриа зөв, тогтвортой тавьсан хэн бүхэн хямралыг даван туулж, тэр бүү хэл илүү өндөрлөгт хүрч чадна.



Маркус Эппэр BPN Монгол салбарын үйл ажиллагаа хариуцсан захирал

Монгол улсын эдийн засаг 2013 онд хоёр оронтой тоогоор өсч байсан. Гэвч энэ жил эдийн засаг зогсонги байдалтай байгаа бөгөөд ирэх жил ч хүнд хэвээр байна гэж шинжээчид үзэж байна. Эдийн засгийн хүнд нөхцлөөс гарахад Монгол улсад тулгуур хүчин зүйлс хэрэгтэй. Түүний нэг нь гарцаагүй жижиг, дунд аж ахуйн нэгжүүд юм. Учир нь тэд эдийн засгийн өсөлтөөс гадна, улс орны хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулдаг. Тэд нэмүү өртөг бий болгож, ажлын байрыг нэмэгдүүлдэг.

Сүүлийн жилүүдэд бизнес эрхлэгчдэд тавигдах шаардлага өсөн нэмэгдэж байна. Компани урт хугацаанд амжилттай оршин тогтнохын тулд нэгдмэл зорилгын төлөө бүх нөөц бололцоогоор ажиллах нь чухал. Үүний тулд бизний эрхлэгч дараах асуултуудыг өөрөөсөө асууж байх хэрэгтэй.

- Өнөөдөр би хаана зогсож байна?

- Би компаниа ямар замаар хөгжүүлэхийг хүсч байна?

- Урьд өмнө тооцоолоогүй хүндрэл бэрхшээл тулгарвал би хэрхэн даван туулах вэ?

Компанийн хамгийн том зорилго бол хэрэглэгчийг сэтгэл хангалуун байлгаж, эдийн засгийн хувьд тогтвортой, амжилттай ажиллах нь чухал юм. Энэ зарчим нь компани бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж байгаагаас үл хамааран үйлчилдэг. Түүнчлэн компани 100 ажилтантай байна уу, нэг хүний компани уу гэдгээс мөн үл хамаарна.

Эдийн засгийн хувьд энэхүү зорилгодоо хэрхэн хүрч чадах вэ? Бид компанийг онгоцтой зүйрлэж авч үзэж болно. Учир нь компанийг зорчигч тээврийн онгоцтой зүйрлэж ойлгоход хялбар байдаг. Тэгэхлээр компанийн хэмжээ нь онгоцны хэмжээтэй ижил гэсэн үг. Харин онгоцон дох зорчигчид нь компанийн хэрэглэгчид юм. Тухайн авиа компани буюу онгоцыг дахин сонгон үйлчлүүлэх үү үгүй юу гэдэг сонголтод зорчигчдод олон хүчин зүйл нөлөөлдөг. Тухайлбал хэрэглэгчийн хувьд үнэ буюу авч буй үйлчилгээ, тухайн ажилтны зан харьцаа, санал болгож буй зүйл нь хир сэтгэл татахуйц байна, цагаа хир мөрдөж байна, ямар үйлчилгээ үзүүлж байна гэх мэт. Хэрэгчдэд сэтгэл хангалуун үйлчилгээ үзүүлэх үүргийг онгоцны экипаж тэр



чигээрээ хүлээдэг. Тэд зорчигчдыг тав тухтай байлгаж, нислэгээ аль болох тааламжтай үйлдэх тал дээр анхаардаг. Үүний тулд мэргэжлийн ур чадвар болон хувь хүний харилцааг хослуулах нь чухал байдаг.

Нисгэгч онгоц, тээвэрлэлт болон зорчигчдын өмнө хариуцлага хүлээдэг. Тэр аялалыг төлөвлөж, техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавихаас гадна цаг агаарын өөрчлөлтөд аль болох хурдан хариу үйлдэл үзүүлэхийн тулд онгоцны замын туулах цаг агаарын байдалд хяналт тавьж, алсыг харсан нислэг үйлддэг. Нисгэгч удирдлагыг гартаа авч, онгоцны бүхээгийн гол мэдээллүүд хэвийн байгаа эсэхийг хянадаг.

Тэгэхлээр бизнес эрхлэгч таныг нисгэгчтэй зүйрлэж болно. Таны жижиг эсвэл том онгоцны нисгэгч байх нь огт хамаагүй. Бизнес эрхлэгч стратеги менежментийг хариуцан ажилладаг. Тэр нь юу гэсэн үг вэ гэвэл зөв эхлэл (компанийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх)-ээ тавьж, аялалын үед эрсдэлийг урьдчилан тооцож, эртнээс бэлдэх (стратегии удирдлага) мөн баталгаатай газардахыг хэлж байгаа юм.

Стратеги менежмент нь удирдлагын систем бөгөөд үүнийг хамгийн дээд түвшний удирдлагаас өөр хэн ч ойлгодоггүй. Тиймээс удирдагч та урт хугацаанд бизнесээ амжилттай удирдан явуулахын тулд онгоцны бүхээгийн хэрэгслүүдийг зорилгод нийцүүлэхээс гадна үр дүнгийн хяналтад тогтмол хяналт тавих нь чухал. Энэ нь нөхцөл байдал сайн бус мөн хямралын үед хамаарна.

BPN-ийн дэмжих хөтөлбөр нь бизнесийн удирдлагын чухал мөн амьдралд ойр хэрэгслүүдийг зааж өгөхөөс гадна, бизнес сэтгэлгээ, хандлагыг хөгжүүлдэг.

Ирж буй шинэ онд та бүхэнд алсыг харсан нислэгээ амжилттай үйлдэж, амжилттай газардахыг хүсэн ерөөе.



О.Эрдэнэсүрэн: 2016 оны сургалтууд

БPN Монгол салбар үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш нийт 12 удаагийн үндсэн сургалтад 400 орчим бизнес эрхлэгч хамруулсан байна. 2016 оны хувьд манай хөтөлбөрийн хувьд амжилттай жил болж өнгөрч байна. Хөтөлбөрт хамрагдсан бизнес эрхлэгчид болон тэдгээрийн ажилтан, гэр бүлийнхэн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагддаг үндсэн болон нэмэлт сургалтуудад хамрагдаж, өөрсдийн бизнесийг амжилттай удирдан мэргэжлийн бизнес эрхлэгчдийн түвшинд хүрэхээр зорин ажиллаж байна.

2016 он манай бизнес эрхлэгчдийн хувьд улс орны эдийн засгийн байдал, валютын ханшны хурдацтай өсөлт гэх мэт олон шалтгааны улмаас хүндхэн он байсан. Гэсэн хэдий ч хямралыг боломж хэмээн харж, сургалтуудаар олж авсан мэдлэгийг практикт хэрэгжүүлэх гэж чармайн өөрсдийн үүрэг хариуцлагыг ухамсарлан эх орондоо нэмүү өртөг шингээн баялагийг бүтээж байгаа нь бидний бахархал юм. Бид энэ онд үндсэн 4, нэмэлт 2 сургалтаас гадна “Төслийн менежмент” сургалтыг хөтөлбөрийн оролцогчид болон сонирхсон хэн бүхэнд нээлттэй зохион байгууллаа. Сургалт маань тэдний хүлээлтэд нийцсэн сургалтуудын маань нэг болсон. Энэхүү сургалтаар бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй чухал сэдвүүдийг ярьж, өөрсдийн төслийг амжилттай хэрэгжүүлэхэд нь түлхэц болж чадсан. Мөн сургалтын оролцогчид маань багт хуваагдан өөр өөрсдийн төсөл дээр ажиллаж байсан нь багаар хэрхэн зөв ажиллахын ач холбогдлыг ойлгож авч байсан нь харагдаж байсан. 2016 онд нийт 7 сургалтад 150 гаруй бизнес эрхлэгчид хамрагдсанаас 62 нь манай хөтөлбөрийн оролцогчид, үлдсэн хэсэг нь салбар бүртээ амжилттай ажиллаж байгаа бизнес эрхлэгчид болон менежерүүд байлаа. Түүнчлэн бид бүхэн энэ онд нийт 11 удаагийн бизнес төлөвлөгөө болон санхүүгийн бүртгэлийн сургалтад зохион байгуулж, 90 орчим бизнес эрхлэгчийг хамрууллаа. Цаашид бид жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнесийн удирдлагын түвшинд чадавхижуулах мөн түүнчлэн сургалтаар олж авсан мэдлэгийг практикт зөв хэрэгжүүлэх тал дээр анхаарлаа хандуулан манай ажилтнууд зөвлөгөө өгч ажиллана.



Сургалтын хуваарь



“Санхүүгийн менежмент”
2017.04.26 - 04.29 /4 өдөр/
Удирдагч: Ханс Вилхэлм

Зорилго: Сургалтаар санхүүгийн үндсэн ойлголтуудыг таниулах ба бизнес эрхлэгч компанийнхаа мөнгөн урсгалыг хянаж, зөв тооцоолсноор бизнесээ амжилттай удирдаж, зорилгодоо хүрэх мэдлэг чадвар эзэмшинэ. Мөн санхүүгийн тооцооллын аргууд, хугарлын цэг цаашилбал үйлдвэрлэлийн зардал болон ашгаа тооцох хэрэгслүүдтэй танилцаж, ашиглах сурах чадвар эзэмшинэ.

Ерөнхий агуулга: Эргэлтийн хөрөнгийн менежмент, санхүүгийн тайлан баланс, үр дүнгийн тайлан, тооцооллын чухал аргачлалууд, үнэ болон өртөг тооцох, хугарлын цэг



“Маркетинг”
2017.05.01 - 05.05 /4 ½ өдөр/
Удирдагч: Маркус Эппэр

Зорилго: Маркетингийн гол хэрэгслүүдийг бизнес эрхлэгчдэд таниулан, тэдгээрийг үйл ажиллагаандаа зөв хэрэглэх арга барилд суралцуулж, өөрийн бизнест тохирсон маркетингийн төлөвлөгөөг бие даан боловсруулах чадвар эзэмшүүлнэ.

Агуулга: Маркетингийн иж бүрдэл, хэрэглэгчидтэй харьцах, санал гомдлыг хүлээн авах, бизнес эрхлэгчийн зарчим: зах зээл, борлуулалтын сувгийг сонгох, маркетингийн гол хэрэгслүүд, маркетингийн төлөвлөгөө, төсөв, Mc Kinsey матриц эх мэт.



Бизнес эрхлэгчдийн нийгэмлэг



Бизнес эрхлэгчдийн нийгэмлэг нь БPN-ийн үйл ажиллагааны үндсэн нэг чиглэл юм. Монгол салбарын хувьд 2017 онд нийгэмлэгийн үйл ажиллагаагаа эхлүүлж, эхний арга хэмжээгээ явуулахаар төлөвлөж байна. Бизнес эрхлэгчдийн нийгэмлэг нь БPN Монгол салбарын харъяа байх бөгөөд жижиг, дунд бизнес эрхлэгчдийг холбосон, тэдний үйл ажиллагаанд чиглэгдсэн байна. Манай нийгэмлэгийн гишүүнчлэлд БPN-ийн хөтөлбөрт хамрагдаж буй болон сайн дураар нэгдсэн бизнес эрхлэгчид хамрагдана. Нийгэмлэгийн зорилго нь жижиг, дунд бизнес эрхлэгчид эдийн засаг, нийгмийн хүрээнд харилцан бие биенээ дэмжин, бизнесийн эрхзүйн орчинд нөлөөлж, Монгол улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулан ноу-хау болон дадлага туршлагаа хуваалцахад оршино. Түүнчлэн нийгэмлэгийн гишүүн бизнес эрхлэгчид БPN-ийн бизнес академийн хүрээнд явагдаж буй сургалтуудад хамрагдах боломжтой. Ингэснээр бизнесийн удирдлагын түвшинд чадавхижиж, “Монголд үйлдвэрлэв” бүтээгдэхүүнийг чанарын ахисан түвшинд хүргэн, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Бизнес эрхлэгчид ижил төрлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, өөрсдийн дуу хоолойг нийгэмд хүргэх тал дээр хувь нэмрээ оруулна. Нийгэмлэгийн гишүүд тогтмол уулзалт, арга хэмжээ зохион байгуулж, өөрт тулгарч буй асуудал, саад бэрхшээлийг хамтран шийдвэрлэх арга замыг тодорхойлж, санал бодлоо солилцох юм. Нийгэмлэгийн удирдах зөвлөл нь салбартаа тэргүүлж буй бизнес эрхлэгчдээс бүрдсэн байх бөгөөд гишүүдийн саналаар нийгэмлэгийн удирдлагыг сонгоно. БPN Монгол салбарын бизнес эрхлэгчдийн нийгэмлэгийн үйл ажиллагаанд хамрагдаж, идэвхтэй оролцох хүсэлтэй бизнес эрхлэгч таныг бидэнтэй холбогдож, санал бодлоо хуваалцахыг урьж байна. Бизнес эрхлэгч танд манай үүд хаалга үргэлж нээлтэй байх болно.

О.Эрдэнэсүрэн

М.Даваажав: Энэ оны хөтөлбөрийн оролцогчид



Манай хөтөлбөр Монгол улсад үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бизнесийн удирдлагын суурь мэдлэг олгох сургалтуудаа явуулахаас гадна жил бүр тодорхой тооны бизнес эрхлэгчдийг хөтөлбөртөө хамруулж, тогтвортой дэмжсээр ирсэн билээ. Хөтөлбөрт оролцож буй бизнес эрхлэгчдийн хувьд өөрийн бизнес дээр бодит нөхцөл байдалд суурилсан менежментийн зөвлөгөө авах том давуу талтай байдаг билээ. БPN Монгол салбарын багийнхан бид бүхэн 2017 онд шинээр нийт 60 бизнес эрхлэгчийн үйлдвэр болон үйл ажиллагаатай танилцсанаас 30 гаруй бизнес эрхлэгчтэй гэрээ байгуулж, хөтөлбөртөө хамруулаад байна. Хөтөлбөрийн шинэ оролцогчид маань бүгд бизнес төлөвлөгөө болон санхүүгийн бүртгэлийн анхан шатны сургалтад хамрагдсан бөгөөд “Бизнесийн удирдлага” сургалтандаа амжилттай оролцлоо. Шинэ хөтөлбөрийн оролцогчдын хувьд талх нарийн боов, сүлжмэл, оёдол, барилга болон хүнсний зэрэг бүхий л салбарын төлөөллөөс бүрдэж байгаа юм. Энэ оны хөтөлбөрийн оролцогчдын хувьд үйл ажиллагаагаа явуулж эхлээд удаагүй боловч зах зээлд хурдан танигдаж, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж байгаагаараа маш онцлогтой байна. Хөтөлбөрийн шинэ оролцогчдын заримаас дурьдвал “Билгүүнжин хөнжил” ХХК, “Хөх урлан” ХХК, “Айпл мүүн” ХХК, “Сайн бүрээс” ХХК, “Булган цагаан нуур” ХХК, “Шүр кашмер” ХХК, “Өөдлөн дэвжих” ХХК, “Чиглэл” ХХК, “Өгөөж шим” ХХК, “Түмэн ашиг” ХХК буюу Хазаар брэнд, “Урангоо Идэр” ХХК зэрэг салбар бүрийн төлөөллүүд юм. Манай шинэ хөтөлбөрийн оролцогчдын төлөөлөлтэй сонингийн 6, 7-р нүүрээс танилцах боломжтой. Бизнес эрхлэгчид бүгд өөрийн гэсэн туршлага, бизнес эрхлэх арга барилтай байдаг. Хөтөлбөрт хамрагдаж буй бизнес эрхлэгчдийн хувьд зөвхөн сургалтуудад хамрагдах бус, хоорондоо танилцах, хамтран ажиллах боломжуудыг судлах, туршлага солилцох зэрэг олон талын ач холбогдолтой.



**Хөтөлбөрийн
оролцогч
Ц.Нямжав**

“Өгөөж Шим” ХХК нь 1999 онд байгуулагдсанаас хойш ноос, ноолуурын салбарт ажиллаж ирсэн бөгөөд 2011 онд өөрсдийн үйлдвэрийг байгуулсан. Одоогоор ноос, ноолуурын анхан шатны самнах болон угаах үйлдвэрлэлийг явуулж байгаа ба үндсэн үйл ажиллагаа нь самнасан ноолуурын гадаад дотоод худалдаа, ноолууран утасны дотоод худалдаа юм.

Тус компани нь 2012 оноос эхлэн дотоодын зах зээлд ноолууран утас, тэмээ, сарлагийн ноосон утас үйлдвэрлэн дотоодын үйлдвэрүүдийн хэрэгцээг хангаж эхэлсэн. Манай компани нь дотоодын 60 гаруй ЖДҮ үйлдвэрүүдтэй хамтран ажиладаг бөгөөд МҮХАҮТ болон Ноос, ноолуурын холбооны гишүүн байгууллага юм. 2008 оноос гадаад худалдааны зах зээлээ өргөжүүлэн ажиллаж ирсэн бөгөөд Энэтхэг, Солонгос, Япон, Орос зэрэг улсууд руу бүтээгдэхүүнээ нийлүүлдэг.

Монгол улс бол ХАА-н уламжлалт үйлдвэрлэлийн улс бөгөөд малын гаралтай түүхий эдийн үйлдвэрлэл бол манай улсын өрсөлдөх боломжтой салбар гэж үздэг. Монгол улсад байгаа ХАА-н гаралтай түүхий эдийг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадвал дэлхийн зах зээл биднээс холгүй байна.

Бидний, манай компанийн зарчим бол шударга бөгөөд тогтвортой бизнесийг хөгжүүлэх явдал юм. Миний хувьд бизнес эрхэлж байх явцдаа ойлгосон нэг чухал зүйл бол зөвхөн дотоод орчноо анхаарах биш гадаад орчны өөрчлөлт, нөлөөллийг анхаарч



байх хэрэгтэй юм байна. Мөн эрсдэлийг тооцож, аливаа асуудлыг үүсэхээс сэргийлж чадвал компанийн үйл ажиллагаа хэвийн явагдах боломж бүрдэнэ.

Монголын бизнес эрхлэгч нарт тулгардаг нэг нийтлэг том асуудал бол үйлдвэрлэл эрхлэх ур чадвар болон хүний нөөцийн дутагдал юм. Үйлдвэрлэл эрхлэх ур чадварыг өөрсдийн туршлага болон шаадлагатай сургалтаар дамжуулж сайжруулах боломжтой болгох байх. Харин чадварлаг хүний нөөцийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар бэлдвэл зах зээлийн шаардлагад илүү нийцэх боломжтой болно.

ВРN-ийн хөтөлбөрийн талаар өмнө нь сонссон боловч албан ёсоор 2016 оноос эхлэн хамтран ажиллаж байна. Одоо миний хувьд бизнес төлөвлөгөө, санхүү бүртгэл, төслийн менежмент, маркетинг зэрэг сургалтуудад хамрагдсан. Эдгээр сургалтуудад хамрагдсанаар бизнес эрхлэгчдэд өдөр тутам тулгардаг асуудлыг энгийн ойлгомжтой байдлаар шийдэхэд тусалж байна.

Манай компанийн хувьд сургалтанд хамрагдсаны үр дүнд ажлаа сар, улирал, жилээр төлөвлөдөг болсон. Мөн төлөвлөгөөний дагуу урьдчилсан төсөв боловсруулж, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

***“Сургалтад хамрагдсаны үр
дүнд ажлаа сар, улирал, жилээр
төлөвлөдөг болсон.”***



**Хөтөлбөрийн
оролцогч
Ц.Бумцэнд**



Манай компани нь анх 1990 онд нийтийн хоолны тоног төхөөрөмж, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар, угсралтын чиглэлээр “ЧИГЛЭЛ” ББХХоршоо нэртэйгээр үүсгэн байгуулагдсан. 1996 оноос “Чиглэл” ХХК нэртэйгээр өргөжин хүнс нийтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын гал зуухны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, угсралт, худалдаа нийлүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2005 онд БНХАУ-аас тоног төхөөрөмж, үйлдвэрлэх машин техник, багаж оруулж ирэн хэрэглэгчийн захиалгаар болон өөрсдөө зохион бүтээж, Монгол улсын брэнд бүтээгдэхүүн болгохоор дотооддоо үйлдвэрлэн, импортыг орлох, гадагш гарах мөнгөний урсгалыг бууруулах, жижиг дунд үйлдвэрийг дэмжих, үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилтын дор засгийн газраас хэрэгжүүлж байгаа хөтөлбөртэй уялдуулан ажиллаж байна. Энэ хугацаанд бизнесээ өөрийн эзэмшсэн мэргэжлийнхээ дагуух мэдлэг практик, туршлагаараа, өөрөөр хэлбэл зөн совин, мэдрэмжээрээ удирдан явуулж байлаа. Үйл ажиллагаа маань өргөжин тэлэхийн хирээр асуудлууд олширч эхэлж байлаа. Иймээс бизнесийн онол, судалгаа шинжилгээг үндэслэн, бизнесийн төлөвлөгөөтэй үйл ажиллагаагаа явуулах хэрэгтэйг ойлгосон ч яг хаанаас яаж эхлэх аргаа мэдэхгүй байсан юм. Мөн бид бизнес төлөвлөгөөг хэрхэн оновчтой бичих, бичсэн төлөвлөгөөгөө бодит байдал дээрээ хэрхэн хэрэгжүүлэх аргыг мэддэггүй байлаа.

Анх ВРN-ийн талаар 2015 онд мэдээлэл авч 2016 онд өөрийн биеэр маркетингийн сургалтад суусан.



Сургалт бодитой үр өгөөжтэй ойлгомжтой байсан тул дараагийн бизнес төлөвлөгөө, санхүү бүртгэлийн сургалтанд том охинтойгоо хамт суралцсан. Дараа дараагийн бүх сургалт хөтөлбөрүүдэд хүүхдүүдтэйгээ хамт өөрийн биеэр оролцох төлөвлөгөөтэй байгаа. Бид ВРN-ийн сургалтад сууж хөтөлбөрт хамрагдсанаар мэргэжлийн хэмжээнд бизнесийн үйл ажиллагаагаа явуулах нь ямар их ач тустай болохыг ойлгож авсан. Мөн ВРN нь практикаас авсан туршлагыг бизнес, эдийн засгийн онолтой холбож, хэрхэн мэргэжлийн түвшинд бизнесээ удирдах аргыг маш ойлгомжтой энгийнээр зааж өгсөн юм.

ВРN-ийн хөтөлбөр нь манай компанийн үйл ажиллагаа, чиглэлд зориулан яг тохирсон, үр өгөөжтэй, бизнесийн зөвлөгөө өгдөгт бид маш их талархаж байна. Мэргэжлийн түвшинд бизнесээ удирдсанаар манай компани нь ирээдүйд улам хөгжин дэвшиж, урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжтой боллоо.

***“ВРN-ийн сургалтад сууж,
хөтөлбөрт хамрагдсанаар
мэргэжлийн хэмжээнд
бизнесийн үйл ажиллагаагаа
явуулах нь ямар их ач тустай
болохыг ойлгож авсан.”***